



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 101

Эрдэнэт

Журам шинэчлэн
батлах тухай

Аймгийн ИТХ-ын байгууллагын ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох Төлөөлөгчдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хурал, нутаг дэвсгэр, багт ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн Хурал, нутаг дэвсгэр болон багт ажиллах, зардал олгох, тайлагнах журмыг нэгдүгээр хавсралтын ёсоор, тухайн сард ажилласан мэдээний загварыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Д.Эрдэнэцэцэг/-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 44 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА

00100289